



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/148

Хэрлэн сум

"Өрх бүр ногоон үйлдвэрлэгч  
аян" өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "б", 30 дугаар зүйлийн 30.1.1, Засгийн газрын 2016 оны 45 дугаар тогтоолын 2.41, 2.44 дэх заалт, мөн оны 212 дугаар тотоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Атрын-111 аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хэнтий атрын аян"-ыг өрнүүлэх, иргэдийн төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Өрх бүр ногоон үйлдвэрлэгч" аяныг орон нутагт зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Тус аяны тайланг нэгтгэж, мэдээллээр хангаж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Энх-Амгалан/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 723